

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бугат сумын Ойн ангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2025/005/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn

Булган аймаг

2025 он

Булган аймаг дахь Төрийн аудитын дарга,
тэргүүлэх аудиторовын албан тушаалын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч Ж.Энхцоодол
Утас: 70342580 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
Ахлах аудитор: Г.Намчинсүрэн
Утас: 70342716 Цахим хаяг: Namchinsureng@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу,



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025.03.13 № 328

танай _____ ны № _____ т

БУГАТ СУМЫН ОЙН АНГИЙН
ДАРГА С.ЛХАГВАБААТАР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бугат сумын Ойн ангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Булган аймгийн Бугат сумын Ойн анги нь өмнөх оны талбай тусгаарлалтын авлагыг барагдуулаагүй, мөн тайлант онд 4,049.0 мянган төгрөгийн талбай тусгаарлалтын авлагыг барагдуулаагүй зэрэг зөрчил нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.4 дахь заалт болон санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй ба бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн баталсан байна. Үүнтэй холбоотойгоор ИТХ-аар цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардалд тодотгол хийгдэж өмнөх оноос 56 хувиар өссөн байна.

632501644

Аудитын гол асуудал

Булган аймгийн Бугат сумын Ойн анги нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудыг бэлтгэхдээ Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын дагуу бэлтгээгүй байна.

Бусад асуудал

Тус байгууллага нь 2024 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 26 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 93 хувьтай үнэлүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ТУШААЛЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Ж.ЭНХЦООДОЛ

Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31.
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	14,662.7	8,756.4
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	-	-
Нийт хөрөнгийн дүн	14,662.7	8,756.4
Нийт өр төлбөрийн дүн	12,187.8	10,180.9
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,474.9	(1,424.5)
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	14,662.7	8,756.4
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	20,179.0	45,117.4
Үйл ажиллагааны зардлын дүн	17,704.1	49,016.8
Үйл ажиллагааны үр дүн	2,474.9	(3,899.3)
Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
Үйл ажиллагааны нийт үр дүн	2,474.9	(3,899.3)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	2,474.9
Тайлант оны үр дүн	2,474.9	(3,899.3)
Эцсийн үлдэгдэл	2,474.9	(1,424.5)
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	30,561.5	41,353.6
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	17,461.9	51,610.9
Үйл ажиллагааны ЦМГ	13,099.6	(10,257.3)
Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	-
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	13,099.6	(10,257.3)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	13,099.6
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	13,099.6	2,842.3
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	-	51,610.9
Урсгал зардал	-	51,610.9
Хөрөнгийн зардал	-	-
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	-	41,353.6
Улсын төсвөөс санхүүжих	-	-
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	41,353.6

Гурав.Байгууллага, түүний үйл ажиллагаа

Бугат сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн VII/12 дугаар хуралдаанаар ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7 дахь заалтыг үндэслэн сумын ойн санг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх, үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд явуулах, арга зүйн зөвлөгөөгөөр хангах үүрэг бүхий сумын ойн анги байгуулсан байна.

Тухайн ойн анги байгуулагдсанаас хойш ойн ангийн дарга 2 удаа, нягтлан бодогч 2 удаа солигдсон нь тухайн байгууллага үндсэн үүргээ чиг бүрэн хэрэгжүүлэх эрсдэлтэйг харуулж байна.

Дөрөв. Аудитын илрүүлэлт

Аудитаар Санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан " Аж ахуй нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх" зааврын дагуу тайлагнаагүй залруулагдаагүй алдаанд нэг зөвлөмж хүргүүлсэн.

Нийт илэрсэн 4,770.0 мянган төгрөгийн зөрчилд 4,770.0 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 4,770.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 4,570.9 мянган төгрөгөөр их тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлага данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Өмнөх оны тусгаарлалтын авлагыг барагдуулаагүй мөн тайлант онд нэмж талбай тусгаарлалтын авлага үүссэн нь төсвийн тухай хуулийн 6.4.8, 16.5.2, 16.5.4-д заасан заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй нь санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6.4.4, 16.5.2, 16.5.4-д заасан заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллах

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Булган аймгийн Бугат сумын ойн анги	1				1	1			1		1	
Дүн	1	-	-	-	1	-	-	-	1	-	1	

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Булган аймгийн Бугат сумын ойн анги	1	4,770.0					1	4,770.0				
Дүн	1	4,770.0					1	4,770.0				

